



Food and Agriculture
Organization of the
United Nations

Богино хэмжээний дүрс бичлэгийн уралдаан

Хүнс, хөдөө аж ахуйн өв соёл залуусын нүдээр

Олон Улсын Залуучуудын өдөр



Ерөнхий мэдээлэл

Хүн ба байгалийн харилцан шүтэлцээгээр бий болсон Хөдөө аж ахуйн өв соёл нь хүн төрөлхтний аж төрөх арга ухааны нэг юм. Энэхүү өв нь соёл-экологийн уламжлалыг үе дамжуулан шингээн оршин тогтнодог бөгөөд хүн ардын хүнсний баталгаат байдлын үндэс суурь болдог.

Уур амьсгалын өөрчлөлт, хотжилт зэрэг шалтгаанаас олон үндэстний хөдөө аж ахуйн өв соёл, ялангуяа, нүүдэлчдийн уламжлалт арга ухаан бага багаар бүдгэрсээр байна. Хүн төрөлхтний хөдөө аж ахуйн өв соёлын гуравны нэг хэсэг устаж үгүй болох эрсдэлд орсон байна.

Дэлхий дахинаа хөдөө аж ахуйн салбар насжилтын асуудалтай тулгарч байгаа энэ үед залуусын шинэлэг санаа, идэвхтэй оролцоо маш чухал байна. Өв соёлоо хадгалж байгаа бүтээлч арга, туршлагыг хуваалцах нь залууст хөдөө аж ахуйг сонирхох сэдэл төрүүлэх, тэдний өв соёлоо хадгалах урам зоригийг бадраах, уламжлалт сэтгэлгээг дахин эргэцүүлэн бодох, хөдөө аж ахуй-нийгмийн харилцан уялдааг судлах болон хөдөө аж ахуйн өв соёлыг тогтвортой хөгжлийн зорилготой нийцүүлэн хөгжүүлэхэд залуусын оролцоотой бүтээлчээр шийдэх ач холбогдолтой юм. НҮБ-ын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллага (ХХААБ) жил бүр Итали улсын Ром хот дахь төв байранд **Дэлхийн Хүнсний Форум** (ДХФ) зохион байгуулж хүнс, хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийн талаарх үзэл баримтлалыг дэлхий дахинд нэгтгэдэг.

2025 оны ДХФ-д Монгол, Лаос болон Хятад улсын залуус уламжлалт мал аж ахуй, газар тариалангийн арга барилыг сайжруулахад шинэ технологи, шинэлэг санаачлагатай хослуулсан шийдлүүдээ танилцуулахаар уригдсан болно.

Энэ хүрээнд болон **2025 оны 8 дугаар сарын 12-нд тохиох Олон улсын Залуучуудын өдрийг тохиолдуулан, ХХААБ-аас “Хүнс, хөдөө аж ахуйн өв соёл залуусын нүдээр” богино хэмжээний дүрс бичлэгийн уралдаан зарлаж байна.**

Залуусыг хүнс, хөдөө аж ахуйн тогтолцоо, хөдөө аж ахуйн өв соёл, нүүдлийн соёлд тулгарч буй тулгамдсан асуудлыг тодорхойлон, шийдвэрлэх шинэлэг шийдлийг олж толорхойлон энэ уралдаанд оролцохыг урьж байна.



Уралдаанд оролцох

Дараах чиглэлээр бакалавр, мастер болон докторын зэргийн хөтөлбөрт суралцдаг 18-35 насны байх. Үүнд:

- Хөдөө, аж ахуй
- Хүнсний тогтолцоо /Хүнсний баталгаат байдал
- Хөдөөгийн хөгжил / Тогтвортой хөгжил
- Байгаль орчин (ой, агроэкологи, ус, газар, хөрс, гэх мэт)
- Уур амьсгалын өөрчлөлт

Бүтээлд тавих шаардлага

1. Дүрс бичлэг (1-3 мин)

Агуулга: Хөдөө аж ахуй, хүнсний тогтолцоо, монголын уламжлалт хөдөө аж ахуйн өв соёлын асуудал тодорхойлон, шинэлэг шийдэл санал болгосон байх. Асуудлаа маш сайн тодорхойлж, санал болгож буй шийдлээ тодорхой тайлбарлаж, өвөрмөц, шинэлэг шийдэл, өв соёлоо хадгалахад анхаарсан байна.

Хэл: Монгол буюу Англи (Монгол хэлээр хийсэн тохолдолд англи хадмал орчуулгатай байх).

Формат: дурын төхөөрөмж (гар утас, камер гм.) ашиглаж болно. Дуу, дүрс тодорхой, ойлгомжтой байх.

2. Үзэл баримтлалын бичвэр

A4 хэмжээний 1 хуудсанд багтаан доорхи агуулга бүхий бичвэрийг Англи хэл дээр бичих.

·Асуудал - Шийдэл - Шийдлийн нөлөө

Бүтээлээ явуулах

Дүрс бичлэг болон бичвэрийг доорхи холбоосоор нэвтэрч 2025 оны 9-р сарын 5-ны дотор ирүүлнэ үү:

<https://docs.google.com/forms/d/e/1FAIpQLSdZuwwhhQFIInyRVXfJ0Tlh3DIoGkPCzJ5AljET9Vnj0ragJgg/viewform?usp=header>



**Материал хүлээн авах
хугацаа: 2025 оны 9-р сарын 5
хүртэл**

Ялагчийг 2025 оны 9-р сарын 12-нд
зарлах болно

Шагнал

Нэг бүтээлийг шилдэгээр шалгаруулж дараах арга хэмжээнд нэг оролцогч орох эрхээр шагнана. Үүнд:

- ХХААБ-ын Монгол дахь төлөөлөгчийн газрын Улаанбаатар хотод 2025 оны 10-р сард зохион байгуулах Дэлхийн Хүнсний Өдрийн арга хэмжээ
- ХХААБ-ын 2025 оны 10-р сард Итали Улсын Ром хотод зохион байгуулах ДХФ-ын “Өв соёлд залуусын оролцоо” сэдэвт дагалдах арга хэмжээнд тус байгууллагын бүрэн дэмжлэгээр оролцох.

